

**АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ
ИМПОРТЛОХ, ЭКСПОРТЛОХ, ДАМЖУУЛАН
ӨНГӨРҮҮЛЭХ ТУХАЙ ХҮСЭЛТИЙГ ЦАХИМААР ХҮЛЭЭН АВАХ,
ХЯНАЖ ШИЙДВЭРЛЭХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Монгол Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн экспортлогч, импортлогч болон хил дамжуулан тээвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжид мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл, амьтан, ургамал бүтээгдэхүүний импортын мэдэгдэл (цаашид “гэрчилгээ, мэдэгдэл” гэх) цахимаар олгохтой холбогдсон байгууллагын дотоод зохион байгуулалтын харилцааг зохицуулахад оршино.

1.2.Гаалийн ерөнхий газар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ, хэлэлцээр, хоёр улсын хооронд байгуулсан нөхцөл, шаардлага, санамж бичиг, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай, Ургамал хамгааллын тухай, Байгалийн ургамлын тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Амьтны тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, “Жагсаалт, журам батлах тухай” Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоол, холбогдох бусад хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх журам, стандарт болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр.Хамрах хүрээ

2.1.Энэхүү журмыг мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, импортын мэдэгдэл, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл авах иргэн, хуулийн этгээд (цаашид “хүсэлт гаргагч” гэх)-ийн гаргасан хүсэлтийг цахимаар хүлээн авах, хянах, бүртгэх, баталгаажуулах, тайлагнах, гэрчилгээ, мэдэгдэл олгох, санхүүгийн тооцоо хийх үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

**Гурав.Албан хүсэлтийг цахимаар
хүлээн авах, хянах, шийдвэрлэх**

3.1.Гаалийн байгууллага нь мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, импортын мэдэгдэл, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл авах аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүсэлтийг /caps.gaali.mn/ цахим хаягаар хүлээн авна.

3.2 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас экспортын гэрчилгээг мэдүүлэхдээ 1 хүсэлтэд 5 хүртэлх бүтээгдэхүүний нэр төрөл, тээврийн хэрэгслийн мэдүүлгийг илгээж болно.

3.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаалийн байгууллагад ирүүлсэн цахим хүсэлтийг Гаалийн хорио цээрийн газрын дарга, гаалийн улсын ахлах байцаагч, Гаалийн газар, хороод дахь дарга, албаны дарга нар танилцаж, хариуцсан хорио цээрийн гаалийн улсын /ахлах/ байцаагчид шилжүүлнэ.

3.4.Хорио цээрийн гаалийн улсын /ахлах/ байцаагч нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, ургамлын эрүүл ахуйн

гэрчилгээ, импортын болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл авах хүсэлтийн холбогдох бичиг баримтыг хянана.

3.5.Хууль, тогтоомжид заасан шаардлагыг хангасан тохиолдолд мал эмнэлэг болон ургамлын хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын (ахлах) байцаагч хүсэлтийг зөвшөөрсөн төлөвт шилжүүлж, хураамжийн нэхэмжлэх үүсгэнэ.

3.6.Иргэн, аж ахуйн нэгжийн илгээсэн төлбөрийн баримтыг хүлээн авсны дараа импортын мэдэгдэл, импортын гэрчилгээг зөвшөөрч, цахим хэлбэрээр гарын үсгийн баталгаажилт хийж бүтээгдэхүүн орох боомтод цахимаар шилжүүлнэ.

3.7 Экспортын гэрчилгээ, дамжин өнгөрөх мэдэгдлийг Монгол улсын холбогдох хуульд заасан заалт, мөн 2 улсын хооронд байгуулсан протокол, санамж бичиг, дамжин өнгөрөх улсын шаардлагын дагуу Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/27 тоот тушаалаар батлагдсан гэрчилгээг олгоно.

3.8 Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/33 тоот тушаалын дагуу Гэрчилгээ, мэдэгдлийн баталгаажилтыг хийнэ.

3.9.Холбогдох баримт бичгийг бүрэн бус, алдаатай ирүүлсэн тохиолдолд тайлбар хэсэгт шаардлагатай мэдээллийг бичиж, хүсэлтийг буцаах төлөвт шилжүүлнэ.

3.10.Баримт бичгийн бүрдлийг хангуулахаар буцаасан хяналтын хугацаанд шаардлага хангаж хариу ирүүлээгүй, гэрчилгээ, мэдэгдэл олгох боломжгүй тохиолдолд албан хүсэлтийн тайлбар хэсэгт үндэслэлийг бичиж, тухайн хүсэлтийг татгалзаж шийдвэрлэнэ.

3.11.Хяналтын хугацаанд багтаан баримт бичгийг ирүүлсэн тохиолдолд буцаасан өдрөөс дахин ирүүлсэн өдөр хүртэлх хоногоор хүсэлтийг шийдвэрлэх хугацааг нэмж тооцно.

3.12.Цахим системд зааснаас бусад баримт бичгийг гэрчилгээ, мэдэгдэл хүсэгчээс шаардахыг хориглоно.

Дөрөв. Гэрчилгээ, мэдэгдэл олгох

4.1.Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.2, 4.3, 4.4-т заасны дагуу экспортын гэрчилгээг англи, орос хэлээр бичих, импортын гэрчилгээг монгол хэлээр, импортын мэдэгдлийг цахим системд экспортлогч аж ахуйн нэгжийн нэрнээс бусдыг монгол хэлээр бичнэ.

4.2.Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, ургамлын эрүүл ахуйн гэрчилгээг 3 хувь, шаардлагатай тохиолдолд 4 хувь, зорчигчийн гар тээшээр авч явах амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд олгох гэрчилгээг 2 хувь бичнэ.

4.3.Мал, амьтан, тэдгээрийн үр, хөврөл, төл импортлох тохиолдолд нэг удаагийн импортлох тоо хэмжээгээр бичнэ. Нэг гэрчилгээ, мэдэгдэл хэдэн хувь бичигдсэнээс үл хамааран адил дугаартай байна.

4.4. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд олгох импортын мэдэгдэл, экспорт, импортын гэрчилгээг ГЕГ-ын даргын баталсан 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/27 тоот тушаалаар баталсан жагсаалт **хавсралт №1 ийг ашиглана.**

4.5.Гэрчилгээ мэдэгдэл олгох, нэвтрүүлэх хилийн боомт, бараа бүтээгдэхүүний жагсаалтыг **хавсралт №2-ийн** дагуу бичнэ.

4.6.Импортын гэрчилгээг хилийн боомт болон гүний (терминаль) хяналтын талбайд ажиллаж байгаа Мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын (ахлах) байцаагч тус тус бичнэ.

4.7.Импортын мэдэгдлийг судалж, шийдвэрлэх хугацаа нь Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.3 дахь хэсэгт зааснаар, экспортын гэрчилгээг судалж, шийдвэрлэх хугацаа ажлын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 6.2.2.1. шийдвэрлэх ерөнхий хугацаагаар бол удирдлага цохолт хийсэн өдрөөс эхэлж тооцон ажлын 7 хоногт; гэж заасны дагуу шийдвэрлэнэ. Илгээсэн бичиг баримт нь зөрчилтэй, шаардлага хангахгүй тохиолдолд ААН, иргэнд буцааж болно. Зөрчлийг арилгаж, шаардлага хангасан бичиг баримтыг дахин илгээсэн өдрөөс эхлэн хугацааг дахин тооцно.

Тав.Гэрчилгээ, мэдэгдэл дугаарлах

5.1.Экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, импортын мэдэгдэл, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл нь 11 орон бүхий дугаартай байна.

5.2.Энэхүү дугаарын эхний 2 орон газар хороодын индексийг/ ГЕГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/33 дугаар тушаалын хавсралт “бүрдүүлэлтийн хэсгийн кодын эхний 2 орон байна./, дараагийн 2 орон тухайн оныг /сүүлийн 2 тоог бичнэ/, дараагийн 3 орон гэрчилгээний төрлийг /ГЕГ-ын даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/27 тоот тушаал/, сүүлийн 4 орон гэрчилгээний дугаарыг тус тус илэрхийлнэ.

5.3.Импортын мэдэгдлийг мал эмнэлгийн хяналт ангиар А үсэг буюу animal гэсэн үгийг илэрхийлж, ургамал хорио цээр Р үсэг буюу Plant гэх үгийг илэрхийлсэн тэмдэглэгээтэй байна.

5.4.Албаны индекс нь ГЕГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/33 дугаар тушаалын хавсралт “бүрдүүлэлтийн хэсгийн кодын эхний 2 орон байна.

5.5.Гэрчилгээ, мэдэгдлийн дугаарлалт нь жил бүрийн 1 дүгээр сарын ажлын эхний өдрөөс эхлэн өөрчлөх бөгөөд тухайн оныг илэрхийлэх сүүлийн хоёр тоог өөрчилж, сүүлийн 4 орныг 0001-ээс эхэлнэ.

5.6.Мал эмнэлгийн гэрчилгээ нь Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 6.3-т заасан хугацаанд, Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ нь тус хавсралтын 6.2-т заасан хугацаанд, Импортын мэдэгдэл 6 сарын хугацаанд, Монгол Улсаас БНХАУ-д экспортлох ургамлын гаралтай уурагжуулсан тэжээлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгосон өдрөөс 15 хоног, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд олгосон өдрөөс 1 сарын хугацаанд тус тус хүчинтэй байна.

5.7.Экспортын гэрчилгээ олгосон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, бүтээгдэхүүний нэр, тоо хэмжээ, гэрчилгээний дугаар, үнэт цаасны дугаар, нэвтрүүлэх боомтын нэр, экспортлох улсын нэр, шийдвэрлэсэн хорио цээрийн гаалийн улсын (ахлах) байцаагч, гарын үсэг зурж баталгаажуулсан эрх бүхий албан тушаалтан, хүлээн авсан этгээдийн мэдээллийг Бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.

5.8.Гэрчилгээний 1 хувийг холбогдох бичиг баримтын хамт Монгол Улсын “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хууль, “Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт батлах тухай” Архивын ерөнхий газрын даргын 2007 оны 160 дугаар тушаал, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар батлах тухай” Архивын ерөнхий газрын даргын 2007 оны 59 болон 160 дугаар тушаалын дагуу архивын нэгж үүсгэн бүртгэлийн дэвтрийн хамт байгууллагын архивт хүлээлгэн өгнө.

5.9 Гэрчилгээ, мэдэгдлийн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 46 дугаар зүйл “Баримт бичгийн хадгалалт, ашиглалт”-ийн дагуу цахим архив үүсгэхийг гэрчилгээ

олгож буй гаалийн улсын байцаагч, түүнд хяналт тавихыг газар хороодын дарга, ахлах, гэрчилгээ мэдэгдлийн мэдээллийн сан бүрдүүлж файл үүсгэх хадгалах хамгаалах асуудлыг Мэдээлэл технологийн төв хариуцаж хяналт тавьж ажиллана.

Зургаа.Гэрчилгээ, мэдэгдлийн хэвлэмэл хуудасны тооцоо хийх

6.1.Гаалийн ерөнхий газрын санхүү, аж ахуйн асуудал хариуцсан нэгж гэрчилгээ, мэдэгдлийг Олон Улсын байгууллагаас баталсан, хоёр улсын хооронд тохирсон загварын дагуу үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хэвлэлийн газраар гэрээ байгуулж хэвлүүлнэ. Гэрчилгээ, мэдэгдэл нууцлалтай, үл давтагдах дугаартай байна.

6.2.Гаалийн удирдах төв байгууллагын саналыг үндэслэн гэрчилгээ, мэдэгдлийн хэвлэмэл хуудсыг шаардлагатай тоо ширхэгээр тусгайлсан хяналтын дор нэгдсэн байдлаар олгож, үнэт цаасны нэгэн адилаар бүртгэнэ.

6.3.Гэрчилгээ, мэдэгдлийн хэвлэмэл хуудсыг харьяа гаалийн газар, хороонд санхүүгийн хэлтэс, нэгжээр дамжуулан олгож, түүнийг хүлээн авах, хадгалах, хуваарилан өгөх ажлыг тухайн байгууллагын нярав хариуцан гүйцэтгэнэ.

6.4.Гэрчилгээ, мэдэгдлийн хэвлэмэл хуудсыг хүлээн авсан болон хэрэглэж байгаа албан тушаалтан тусгай өрөөнд, эсхүл зориулалтын сейфэнд хадгалж, өрөө, сейфиийг лац(ломбо)-даж битүүмжпэн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

6.5.Харьяа гаалийн газар, хорооны нягтлан бодогч гэрчилгээ, мэдэгдлийн хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтад байнгын хяналт тавьж, зарцуулалтын тайланг улирал бүр баталсан маягтын дагуу гаргана.

6.6.Гэрчилгээ, мэдэгдлийн хэвлэмэл хуудасны тооцоог дараах хуваарийн дагуу Гаалийн ерөнхий газрын тооцооны нягтлан бодогчтой хийнэ.

6.6.1.Гаалийн ерөнхий газрын хорио цээрийн гаалийн улсын /ахлах/ байцаагч улирлын сүүлийн сарын 25-ны дотор,

6.6.2.харьяа гаалийн газар, хороо улирал бүрийн дараа сарын 10-ны дотор;

6.6.3.Гаалийн ерөнхий газрын тооцооны нягтлан бодогч гэрчилгээ, мэдэгдлийн хэвлэмэл хуудасны нэгдсэн тайланг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор.

6.7.Техникийн эвдрэл, байгалийн давагдашгүй хүчин зүйл зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гэрчилгээ, мэдэгдлийн хэвлэмэл хуудсыг үрэгдүүлсэн, дутаасан, ашиглах боломжгүй болсон нь холбогдох байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар уг гэрчилгээ, мэдэгдлийг хүчингүй болгоно.

6.8.Холбогдох албан тушаалтан гэрчилгээ, мэдэгдлийн хэвлэмэл хуудсыг өөрийн буруугаас үрэгдүүлсэн, алдсан тохиолдолд энэ тухай 3 хоногийн дотор нэгжийн дарга, холбогдох нягтлан бодогчид мэдэгдэнэ.

Албан тушаалтны буруутай үйлдлээс үрэгдсэн, ашиглах боломжгүй болсон гэрчилгээ, мэдэгдлийг **тухайн үеийн хэвлэсэн үнийн дүнгээр нөхөн төлүүлнэ.** Үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон гэрчилгээ, мэдэгдлийг хүчингүй болгох, нөхөн төлүүлэх тухай Гаалийн ерөнхий газрын даргын тушаал гаргана.

6.9.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн баримт бичиг, системд оруулсан мэдээллээс шалтгаалан гэрчилгээ, мэдэгдэл алдаатай бичигдсэн тохиолдолд уг гэрчилгээ, мэдэгдлийг хүчингүй болгож.дахин бичих ба холбогдох зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

6.10 Гэрчилгээ, мэдэгдлийг хэвлэх явцад компьютер болон хэвлэх машинаас шалтгаалсан, алдаатай хэвлэгдсэн гэрчилгээг актлах бөгөөд тухайн цахим мэдээлэл хадгалах, хэвлэмэл хуудсыг хадгалах архивт хүлээлгэн өгнө. Үүнд нөхөн төлбөр тооцохгүй болно.

6.10 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас илгээсэн нэг хүсэлтэд /экспортын гэрчилгээг мэдүүлэхдээ 1 хүсэлтэд 5 хүртэлх нэр төрөл, тээврийн хэрэгслийн мэдүүлгийг илгээж болно./ Гаалийн газрын даргынтоот тушаалын дагуу хүсэлт тус бүрд 10000 төгрөгний хураамж авна.

6.11.Гэрчилгээ, мэдэгдлийн хэвлэмэл хуудасны зарцуулалтын тооцоог бүрэн хийж дууссаны дараа гэрчилгээ мэдэгдлийн дараагийн хангалтыг хийнэ.

6.12.Харьяа гаалийн газар, хороо гэрчилгээ, мэдэгдлийн болон олгосон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний тоо, хэмжээний тайланг баталсан маягтын дагуу сар бүрийн 20-нд цахим хаягаар болон албан бичгээр гаалийн удирдах төв байгууллагад ирүүлнэ.

6.13.Хил, хорио цээрийн хяналтын газрын мал эмнэлгийн болон ургамлын хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын /ахлах/ байцаагч нар дээрх тоон тайланг нэгтгэж, цаашдын бодлого, төлөвлөлтөнд хэрэглэнэ.

6.14.Гэрчилгээ, мэдэгдэл олгосон бүртгэл, мэдээг www..... татан авч, дүн шинжилгээ хийж, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглана.

Долоо.Хариуцлага

7.1.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД,
БҮТЭЭГДЭХҮҮНД ОЛГОХ ИМПОРТЫН МЭДЭГДЭЛ,
ЭКСПОРТ, ИМПОРТЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ЖАГСААЛТ

УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНД ОЛГОХ ИМПОРТЫН МЭДЭГДЭЛ, ЭКСПОРТЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, НЭВТРҮҮЛЭХ БООМТЫН ЖАГСААЛТ

№	Газар, хорооны нэр	Гэрчилгээ мэдэгдэл олгох бүтээгдэхүүний нэр	Импортын мэдэгдэл олгох боомтын нэр	Экспортын гэрчилгээ бичих боомтын нэр
1	ГЕГ	<ul style="list-style-type: none"> • Стратегийн зориулалттай мах, махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн, • Тусгай зөвшөөрөлтэй ан, ангийн олдвор, түүний бүтээгдэхүүн • Засгийн Газраас тухайн жилд тоо хэмжээг тогтоож экспортлох болон импортлох үржлийн мал амьтан гэрчилгээг олгох • Шаардлагатай тохиолдолд импортын мэдэгдлийг олгох 	Бүх боомт	Бүх боомт
2	Дорнод ГГ	<ul style="list-style-type: none"> •Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний махан бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, •Стратегийн хүнс болон үржлийн малаас бусад мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл. •Монгол гэрийн модон бэлдэц, хадлангийн зориулалттай өвс, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. •Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл. 	Баянхошуу Хавирга Ульхан Эрээнцав Сүмбэр Чойбалсан	Баянхошуу Хавирга Ульхан Эрээнцав Сүмбэр Чойбалсан
3	БигГ	<ul style="list-style-type: none"> • Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний махан бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Стратегийн хүнс болон үржлийн малаас бусад мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл. • Монгол гэрийн модон бэлдэц, 	Бичигт	Бичигт

		<p>хадлангийн зориулалттай өвс, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ.</p> <ul style="list-style-type: none"> • Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл. 		
4	ЗҮГГ	<ul style="list-style-type: none"> • Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний махан бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Монгол гэрийн модон бэлдэцэд ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, • Тасалсан цэцэг, мод гуалин, модон бэлдэц, • шахмал модон хавтан, фанерьд импортын мэдэгдэл • Мод, модон бэлдэцийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх мэдэгдэл 	Замын-Үүд	Замын-Үүд Ханги
5	Гашуун-Сухайт ГГ Шивээ-Хүрэн ГГ	<ul style="list-style-type: none"> • Гэрийн тэжээвэр амьтанд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Монгол гэрийн модон бэлдэцэд ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. 	Гашуун-Сухайт Шивээ-Хүрэн	Гашуун-Сухайт Шивээ-Хүрэн
6	Бургастай ГХ	<ul style="list-style-type: none"> • Гэрийн тэжээвэр амьтанд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Монгол гэрийн модон бэлдэцэд ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 	Бургастай	Бургастай
7	Ховд ГГ	<ul style="list-style-type: none"> • Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Монгол гэрийн модон бэлдэц, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. • Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл 	Булган, Ховд,	Булган, Ховд, Байтаг
8	Баян-Өлгий ГГ	<ul style="list-style-type: none"> • Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний махан бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Стратегийн хүнс болон үржлийн малаас бусад мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл, • Монгол гэрийн модон бэлдэц, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. 	Цагааннуур, Өлгий	Цагааннуур Өлгий Даян

		<ul style="list-style-type: none"> • Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл 		
9	Увс ГГ	<ul style="list-style-type: none"> • Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Стратегийн хүнс болон үржлийн малаас бусад мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл, • Монгол гэрийн модон бэлдэц, ургамлын болон хөрсний дээж • ид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. • Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл 	Боршоо	Боршоо Цагааннуур Булган Бургастай Тэс
10	Завхан ГХ	<ul style="list-style-type: none"> • Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Стратегийн хүнс болон үржлийн малаас бусад мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл, • Монгол гэрийн модон бэлдэц, ургамал болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. • Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэх импортын мэдэгдэл. 	Арцсуурь	Арцсуурь Булган Бургастай
11	Хөвсгөл ГГ	<ul style="list-style-type: none"> • Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Стратегийн хүнс болон үржлийн мал амьтнаас бусад мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн импортын мэдэгдэл, • Монгол гэрийн модон бэлдэц, ургамлын болон хөрсний дээжид ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ. • Ургамлын үр, үрслэгээ, суулгац, стратегийн хүнснээс бусад ургамал, ургамлын гаралтай түүхий 	Ханх	Ханх Мөрөн Булган Бургастай

		эд, бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл.		
12	СэгГ	<ul style="list-style-type: none"> • Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • ОХУ-аас импортлогдож буй тасалсан цэцэг, мод гуалин, модон бэлдэц, шахмал модон хавтан, фанерьд импортын мэдэгдэл, • Монгол гэрийн модон бэлдэцэд ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, • Мод, модон бэлдэцийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх мэдэгдэл. 	Алтанбулаг Сүхбаатар	Алтанбулаг Сүхбаатар
13	Дархан ГГ	<ul style="list-style-type: none"> • Мах, махан бүтээгдэхүүн, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Мал, амьтны гаралтай түүхий эд /ариутгасан, угаасан, хагас болон бүрэн боловсруулсан ноос, ноолуур, арьс шир/-д импортын мэдэгдэл, • Рапс, хивэг, гурвалжин будаа, монгол гэрийн модон бэлдэц, хөрс. чулуу, шавьж, ургамлын дээж, хатаадаст ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, • Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, мод, модон бэлдэц, үртсэн шахмал хавтан, фанерь, ургамал, ургамлын гаралтай судалгаа шинжилгээний дээж, тасалсан цэцэгт импортын мэдэгдэл. 	Замын-Үүд Алтанбулаг Сүхбаатар Чингис хаан	Замын-Үүд Алтанбулаг Сүхбаатар Чингис хаан Гашуунсухайт Шивээхүрэн Хавирга Баянхошуу Бичигт
14	Орхон ГГ	<ul style="list-style-type: none"> • Мах, махан бүтээгдэхүүн, угаасан ноос, ноолуур, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Мал, амьтны гаралтай түүхий эд /ариутгасан, угаасан, хагас болон бүрэн боловсруулсан ноос, ноолуур, арьс шир/-д импортын мэдэгдэл, • Рапс, хивэг, гурвалжин будаа, монгол гэрийн модон бэлдэц, хөрс, чулуу, шавьж, ургамлын дээж, хатаадаст ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, • Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, мод, модон бэлдэц, үртсэн шахмал 	Замын-Үүд Алтанбулаг Сүхбаатар Чингис хаан	Замын-Үүд Алтанбулаг Сүхбаатар Чингис хаан Гашуунсухайт Шивээхүрэн Хавирга Баянхошуу Бичигт

		хавтан, фанерь, ургамал, ургамлын гаралтай судалгаа шинжилгээний дээж, тасалсан цэцэгт импортын мэдэгдэл		
15	УБГГ	<ul style="list-style-type: none"> • Мал, амьтны гаралтай түүхий эд /ариутгасан, хагас болон бүрэн боловсруулсан угаасан ноос, ноолуур, арьс, шир/, сүү, сүүн бүтээгдэхүүн, яс, мах, дайвар бүтээгдэхүүнээр хийсэн амьтны зориулалттай хоол, тэжээлд, малын яс, өөхнөөс гаргаж авсан бүтээгдэхүүн, ясны гурил, буталсан яс, эвэр, туурай /ангийн олдвороос бусад/, бод, бог малын өлөн гэдэс, лабораторийн шинжилгээний дээж, гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд бүтээгдэхүүнд экспортын мал эмнэлгийн гэрчилгээ, • Мал, амьтны гаралтай түүхий эд /ариутгасан, хагас болон бүрэн боловсруулсан угаасан ноос, ноолуур, арьс, шир/-д, Хагас боловсруулсан мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүнд импортын мэдэгдэл • Монгол гэрийн модон бэлдэц, мод модон материал, хөрс, чулуу, шавьж, ургамлын дээж, хатаадаст ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, • Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, мод, модон бэлдэц, үртсэн шахмал хавтан, фанерь, баяжуулсан тэжээл, тамхины бэлдэц, төрөл бүрийн зөрөг цэцэг, тасалсан цэцэгт импортын мэдэгдэл, 	Замын-Үүд Сүхбаатар Алтанбулаг Чингис хаан	Замын-Үүд Сүхбаатар Алтанбулаг Чингис хаан Гашуунсухайт Шивээхүрэн Булган Хавирга Баянхошуу Бичигт Бургастай
16	Чингис хаан ОУНБ ГГ	<ul style="list-style-type: none"> • Гэрийн тэжээвэр амьтан, зорчигчийн хувийн хэрэглээний маханд бүтээгдэхүүнд экспортын гэрчилгээ 		Чингис хаан

---оОо---